



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах
удирдамж батлах тухай


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах удирдамжийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Удирдамжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг бүх шатны Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга нарт даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар)-т үүрэг болгосугай.

САЙД



Н. УДВАЛ



Эрүүл мэндийн сайдын 2013 оны
143 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах удирдамж

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү удирдамж нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга (цаашид “Эрх бүхий байгууллага” гэх) нарын шийдвэрээр байгуулагдсан комисст (цаашид “Комисс” гэх) хамаарна. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх комисс нь бусад эрх бүхий байгууллагын комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангана.
- 1.2 Комисс нь Аж, ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.12 Эрүүл мэндийн тухай хуулийн 13.4, 15, 40, 41 Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7.1, 9.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахад энэхүү удирдамжийг мөрдлөг болгоно.
- 1.3 “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс” (цаашид “Комисс” гэх) нь үйл ажиллагаандаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлээр тогтоосон зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:
 - Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлага, эрүүл мэндийн салбарт баримталж буй тэргүүлэх чиглэлийг үндэслэх;
 - Тусламж, үйлчилгээ үзүүлэгчдээс зохиомлоор үүсгэх эрүүл мэндийн хэрэгцээ, санхүүгийн эрсдэлээс иргэдийг хамгаалах;
 - Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах;
 - Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
 - Хувь хүний эдийн засгийн эрхийг хамгаалах;
 - Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангах;
 - Ашиг сонирхлын зөрчилгүй байх.
- 1.4 Эрх бүхий байгууллагаас томилогдсон комисс нь эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх ажлын албатай байх ба дараах зохион байгуулалттай байна. Үүнд:
 - Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх комиссын ажлын албаны үүргийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар,
 - Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх ажлын албаны үүргийг Эрүүл мэндийн яамны байгууллагын удирдлага хөгжлийн болон эмийн зохицуулалт хариуцсан нэгж.

- 1.5 Комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бодлого, хэрэгжилт, зохицуулалт хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон иргэдийн эрх ашгийг илэрхийлэх төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий орон тооны бус дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 1.6 Комиссын бүрэлдэхүүнийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр томилж чөлөөлнө. Комиссын нарийн бичгийн даргаар ажлын албаны тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллана.
- 1.7 Комисс нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчдийг татан оролцуулах ба шинжээчийг сонгон шалгаруулж томилно.

Хоёр. Комиссын чиг үүрэг, үйл ажиллагаа

2.1 Комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой ажлын албаны үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах;

2.1.2 Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бодлого, зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

2.1.3 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагыг төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй тэргүүлэх чиглэлтэй уялдуулан тодорхойлж, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийг 2 жил тутамд гарган саналаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх;


2.2 Холбогдох байгууллагын тодорхойлолт, тусгай зөвшөөрлийн шинжээчдийн дүгнэлт, акт зэргийг үндэслэн эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг хэлэлцэн, эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулах;

2.3 Комисс нь Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар хэлэлцэн шийдвэр гаргах;

2.4 Комиссын ажиллах хэлбэр нь хурал байх ба гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэх;

2.5 Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг комиссын дарга батлах ба шаардлагатай үед даргын шийдвэрээр төлөвлөгөөнд тусгагдаагүй асуудлыг нэмэлтээр хэлэлцэж болно. Комиссын хэлэлцэх үндсэн асуудал:

- Тусгай зөвшөөрөл хүсэгчийн шинээр байгуулах эрүүл мэндийн байгууллагын төсөл нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй тэргүүлэх чиглэл, эрүүл



мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлж, албан ёсны хариуг өгөх;

- Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар шийдвэр гаргах;

2.6 Нарийн бичгийн дарга комиссын даргын баталсан хурлын төлөвлөгөө, хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулгыг гишүүдэд хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө цахим ба цаасан хэлбэрээр хүргүүлсэн байна.

2.7 Комиссын дарга хурлын дэгийг батална. Хурлыг ажлын 21 хоногт 1 удаа хийнэ. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан хуралдуулна.

2.8 Комиссын гишүүдийн 70-аас доошгүй хувь оролцсон тохиолдолд хурал хүчин төгөлдөр байна.

2.9 Комиссын гишүүд хурлаар хэлэлцэх асуудалтай бүрэн танилцаж, саналаа бэлтгэж ирэх ба оролцох боломжгүй тохиолдолд саналаа бичгээр болон цахимаар ирүүлнэ.

2.10 Комисс нь шаардлагатай гэж үзвэл комиссын хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох мэргэжилтэн болон шинжээч, тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг оролцуулна.

2.11 Комисс нь хэлэлцсэн асуудлаар санал боловсруулж, тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд комиссын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.12 Тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дангаар болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт хийж, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдол, маргааныг шийдвэрлэнэ.

Гурав. Ажлын албаны чиг үүрэг

Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.


3.1 Тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичгийн бүрдэлтийг хянаж, бэлтгэсэн ажлын байранд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулан, дүнг комиссын хурлаар хэлэлцүүлэх;

3.2 Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагатай харилцаж, тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлсэн баримт бичиг болон бэлтгэсэн ажлын байртай холбоотой мэдээлэл, лавлагааг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

3.3 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын талаар холбогдох хууль эрх зүйн баримт бичиг, олон улсын туршлага, мэдээллийг нягтлан судалж, тусгай зөвшөөрлийн шаардлагыг шинэчлэх сайжруулах санал дэвшүүлэх;

3.4 Шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, сургаж мэргэшүүлэх, арга зүйн зөвлөмжөөр хангах, урамшуулал олгох;

3.5 Ажлын байрны үнэлгээний арга аргачлал, үнэлгээнд ашиглах шалгах хуудсыг боловсруулан хэрхэн ашиглах талаар шинжээч нарт зөвлөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх;



3.6 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг болон ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур, тэдгээрийг үнэлэх, дүгнэлт гаргахтай холбоотой сургалтад шинжээчдийг хамруулах;

3.7 Тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн шаардлагын хэрэгжилтэд явцын хяналт тавих;

3.8 Шударга өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газар, Мэргэжлийн хяналтын байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн алба, хууль хяналтын бусад байгууллага, Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөл, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцох;

3.9 Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаатай холбоотой бүртгэл, мэдээллийн санг хөтлөж, тогтмол баяжуулах;

3.10 Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх байгууллагын тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийг комиссын шийдвэрийг үндэслэн гэрчилгээнд бичилт хийж тэмдэглэх;

3.11 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний маягтыг хэвлүүлэх, 8 дугаар зүйлд заасан зааврын дагуу гэрчилгээг хөтөлж, дугаарлах;

3.12 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг хүлээн авч, тайланг хугацаанд нь гарган харьяа орон нутгийн татварын байгууллагад хүргүүлэх ба энэхүү хураамжийг тооцохдоо Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төлөрийн хэмжээг баримтлах;


3.13 Тусгай зөвшөөрлийн үйлчилгээний төлбөрийг батлагдсан хэмжээгээр төвлөрүүлж, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд зардлын жишгийн дагуу тооцож зарцуулах.

Дөрөв. Шинжээчийн чиг үүрэг

4.1 Эрх бүхий байгууллагаас томилогдсон шинжээчид нь төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хяналт, шалгалт хийх нийтлэг үндэслэл, журмыг удирдлага болгон дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 4.1.1 Ажлын албанаас баталсан удирдамжийн дагуу тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлсэн баримт бичигтэй танилцах;
- 4.1.2 Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байрны бүтэц, үйл ажиллагаа нь холбогдох улсын стандарт, эмнэл зүйн удирдамж, үйлдвэрлэлийн технологийн горимын шаардлага хангаж буй эсэхэд газар дээр нь хяналт, үнэлгээ хийн, холбогдох дүгнэлтийг гаргах;
- 4.1.3 Ажлын байранд тавигдах улсын стандартын шаардлага, шалгуурыг хангахтай холбоотой мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тусгай зөвшөөрөл хүсэгчээс шаардлагатай мэдээллийг гаргуулан авах, зураг авалт хийх;
- 4.1.4 Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шаардлагын хэрэгжилтэд хийх явцын хяналтад оролцох;

- 4.1.5 Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах, ажлын байр өөрчлөгдөх зэрэг тохиолдолд ажлын байрны шаардлагад дүгнэлт гаргах;
- 4.1.6 Тусгай зөвшөөрлийн шаардлагын талаар холбогдох хууль эрх зүйн баримт бичиг, олон улсын туршлага мэдээлэлтэй танилцаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх;
- 4.1.7 Энэхүү журмын 4.1.2, 4.1.5-д заасан дүгнэлтийг комиссын хуралд танилцуулах;



4.2 Шинжээчийг сонгохдоо дараах шалгуурыг үндэслэнэ.

- 4.2.1 Мэргэжлийн болон эрдмийн зэрэг цолтой;
- 4.2.2 Холбогдох мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажиллаж мэргэшсэн, байгууллагын удирдлага, зохион байгуулалтаар ажлын дадлага, туршлагатай;
- 4.2.3 Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай;
- 4.2.4 Тусгай зөвшөөрлийн шаардлагын талаар мэдлэгтэй;
- 4.2.5 Гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

4.3 Шинжээчийг дараах байдлаар сонгож, томилон ажиллуулна.

- 4.3.1 Шинжээчийн сонгон шалгаруулалтын зарыг шалгаруулалт явагдахаас 21 хоногийн өмнө мэдээллийн хэрэгслээр зарлаж зохион байгуулна.
- 4.3.2 Сонгон шалгаруулалтад тэнцсэн шинжээчийг комиссын хурлаар хэлэлцэн баталгаажуулж, 2 жилийн хугацаагаар гэрээ байгуулж, үнэмлэх олгоно.
- 4.3.3 Гэрээ байгуулсан шинжээчдийг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг болон ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур, тэдгээрийг үнэлэх, дүгнэлт гаргахтай холбоотой сургалтад хамруулна.
- 4.3.4 Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байранд үнэлгээ хийх хуваарийг урьдчилан гаргаж, шинжээчид мэдэгдэн, удирдамж болон шалгах хуудсаар хангаж томилон ажиллуулна.
- 4.3.5 Шинжээчид тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байрны үнэлгээ, хяналтад оролцсон хугацаа, ажлын үр дүнг харгалзан эрх бүхий байгууллага ажлын хөлсийг олгоно.

Тав. Комисс, ажлын алба, шинжээчийн ашиг сонирхлын зөрчлийн шийдвэрлэлт

5.1 Комисс, ажлын албаны бүрэлдэхүүний болон түүнийг төлөөлөх этгээдийн (эцэг эх, эхнэр нөхөр, ах эгч, дүү, хүүхэд, найз нөхөд) тусгай зөвшөөрөл эзэмших өргөдөл гаргагчаар оролцож байгаа тохиолдолд ил зарлан, шийдвэр гаргах, санал хураахад оролцохоос сайн дураар татгалзаж, урьдчилан мэдэгдэнэ.

5.2 Шинжээч нь тусгай зөвшөөрөл хүсэгч иргэн, хуулийн этгээдтэй нэгдмэл сонирхолтой байж болохгүй бөгөөд тусгай зөвшөөрөл хүсэгч нь шинжээчийн

34
хамаарал бүхий этгээд (эцэг эх, эхнэр нөхөр, ах эгч, дүү, хүүхэд, найз нөхөд) байх тохиолдолд шинжилгээ хийхээс сайн дураар татгалзаж, урьдчилан мэдэгдэл гаргана.

5.3 Комисс, ажлын алба, шинжээчдийн бүрэлдэхүүн албан үүргээ гүйцэтгэхэд хөндлөнгөөс нөлөөлсөн аливаа дарамт шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар холбогдох хуульд заасны дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зургаа. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх,
хүчингүй болгох үйл ажиллагаа

- 6.1 Тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулах;
- 6.1.1 Ажлын алба нь Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг хүлээн авч, комиссоор хэлэлцүүлэн эрүүл мэндийн байгууллага байгуулах хэрэгцээг тодорхойлж, албан ёсны хариуг тусгай зөвшөөрөл хүсэгчид хүргүүлнэ.
 - 6.1.2 Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байр бэлэн болсны дараа энэхүү тушаалаар баримт бичгийг цаасан хэлбэрээр хүлээн авч, шаардлагатай тохиолдолд ажлын байранд үнэлгээ хийх шинжээчдийг сондгой тооны бүрэлдэхүүнтэйгээр томилж, ажлын удирдамж, шалгах хуудсаар хангана.
 - 6.1.3 Шинжээчид нь томилогдсоноосоо хойш ажлын 5 хоногт багтаан тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичигтэй танилцан, бэлтгэсэн ажлын байрыг улсын стандарт, тусгай зөвшөөрлийн шалгуурын дагуу газар дээр нь үнэлэн дүгнэлтийг комиссын ажлын албанд ирүүлнэ.
 - 6.1.4 Баримт бичгийн бүрдэл хангалтгүй, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон бол хүсэлтийг буцаана.
 - 6.1.5 Шинжээчдийн дүгнэлт ирснээс хойш ажлын 10 хоногт багтаан комиссын хурлаар хэлэлцүүлнэ.
 - 6.1.6 Комисс нь эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинжээчдийн гаргасан дүгнэлтийг үндэслэн санал хурааж зөвшөөрөл олгох эсэх талаар шийдвэр гаргана.
 - 6.1.7 Комиссын гаргасан шийдвэрийг эрх бүхий байгууллага баталгаажуулна.
 - 6.1.8 Ажлын алба нь эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд бичилт хийж, комиссын даргаар гарын үсэг зуруулан баталгаажуулж, аж ахуйн нэгжид олгоно.
 - 6.1.9 Тусгай зөвшөөрөл олгохгүй шийдвэрийг тусгай зөвшөөрөл хүсэгчид албан бичгээр ажлын 3 хоногт багтаан мэдэгдэнэ.
- 6.2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад хяналт тавих, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг зохион байгуулах;
- 6.2.1 Ажлын алба нь тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан чиг үүргийн дагуу гүйцэтгэнэ.

6.2.2 Эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор бүтэц, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт хийж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж өгнө.

6.2.3 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13, 14 зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.10, 19.11 дүгээр зүйлд заасан үндэслэл, шударга өрсөлдөөний зарчим, хэрэглэгчийн эрх ашгийг удаа дараа ноцтой зөрчсөн байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг комиссын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулна.

6.3. Тусгай зөвшөөрлийг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт хийх үйл явцыг зохион байгуулах;

6.3.1 Ажлын алба нь сар бүр тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч байгаа эрүүл мэндийн байгууллагын судалгааг гаргана.

6.3.2 Тусгай зөвшөөрлийн шаардлагад хийсэн хяналт, шалгалт болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох санал гараагүй байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлт гаргаснаас хойш ажлын 3 хоногт багтаан комиссын даргын шийдвэрээр сунгалт хийнэ.

6.3.3 Эрүүл мэндийн байгууллагын хуулийн этгээдийн нэр, үүсгэн байгуулагчийн болон хүний нөөцийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын албанд хүсэлт гаргасан байх ба хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан комиссын даргын шийдвэрээр тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт хийнэ.

6.3.4 Тус тушаалын 6.3.3-т зааснаас бусад ажлын байрны хаяг өөрчлөгдөх, бүтэц, үйл ажиллагаанд нэмэлт өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдөх тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны нэгэн адилаар зохион байгуулж, комиссын хурлаар шийдвэрлэнэ.

Долоо. Тусгай зөвшөөрлийг мэдээлэх

7.1 Ажлын алба нь тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, нэмэлт өөрчлөлт оруулсан эрүүл мэндийн байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрлийн мэдээний санд бүртгэн, цахим хуудас (<http://www.moh.mn>)-ны эрүүл мэндийн салбарын тусгай зөвшөөрөл, импортын зөвшөөрлийн интернэтэд суурилсан (licemed) цахим бүртгэлийн программд байршуулна.


7.2 Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн мэдээллийн сангийн тогтвортой үйл ажиллагааг ажлын алба хариуцна.

Найм. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хөтлөх, дугаарлах

8.1 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг дор дурдсан зааврын дагуу дугаарлана.

8.1.1 Гэрчилгээний дугаар нь үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэгт үйл ажиллагааны төрөл, чиглэлийг заасан үсгэн код, хоёрдугаар хэсэгт зөвшөөрөл олгосон оныг илтгэх хоёр тоо, гуравдугаар хэсэгт эрх бүхий байгууллагын код, дөрөвдүгээр хэсэгт тусгай зөвшөөрлийн дугаарыг нэгж, аравт, зуут, мянгатын

оронтой тоогоор тэмдэглэнэ. Үсгэн кодыг тасалсан богино зураасаар, тоон хэсгийг тасалсан ташуу зураасаар зааглана. Тухайлбал: ЭХ-09/01/01, ЭХ-10/22/133, ТХ-09/24/13676.



8.1.2 Үсгэн код нь тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны төрөл болон эрүүл мэндийн байгууллагын өмчийн хэлбэрийг тодорхойлсон 2 үсэгтэй байна. Тусгай зөвшөөрөл олгоход дараах үсгэн кодыг ашиглана:

Код	Үйл ажиллагааны чиглэл	Өмчийн хэлбэр
ЭУ	Эмнэлэг, сувиллын бүх төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа	Төрийн
ЭХ	Эмнэлэг, сувиллын бүх төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа	Хувийн
ХХ	Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн ханган нийлүүлэх, импортлох, худалдах	хувийн
МХХ	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис ханган нийлүүлэх, импортлох	хувийн
ТХ	Эмнэлгийн багаж тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез ханган нийлүүлэх, импортлох, худалдах	хувийн
ҮХ	Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн үйлдвэрлэх	хувийн
МҮХ	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис үйлдвэрлэх	хувийн
ҮТ	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх	хувийн
АҮХ	Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ	Хувийн
АХ	Ахуйн шавьж, мэрэгч устгал, халдваргүйтлийн бодис импортлох, ханган нийлүүлэх, худалдах	Хувийн
НУ	Өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх	Төрийн
НХ	Өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх	Хувийн
АҮХ*	Ахуйн шавьж, мэрэгч усгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ	Хувийн
ГУ	Эмчилгээний гоо заслын үйлчилгээ	Төрийн
ГХ	Эмчилгээний гоо заслын үйлчилгээ	Хувийн
ЭСХ	Эмийн сан	хувийн

8.1.3 Хоёрдугаар хэсэг нь аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгосон оныг илтгэнэ. Ингэхдээ оны сүүлийн хоёр тоог ашиглана. Тухайлбал: 2003 оныг 03, 2009 оныг 09 гэж тэмдэглэнэ.

8.1.4 Гуравдугаар хэсэгт аймаг, нийслэлийн кодыг тэмдэглэнэ. Жишээ нь: ЭХ-09/05/01, ЭУ-10/23/198

№	Аймаг, нийслэл	Код
1	Архангай	01
2	Баян-Өлгий	02
3	Баянхонгор	03
4	Булган	04
5	Говь-Алтай	05
6	Говь-Сүмбэр	06
7	Дархан уул	07
8	Дорноговь	08
9	Дорнод	09
10	Дундговь	10
11	Завхан	11
12	Орхон	12
13	Өвөрхангай	13
14	Өмнөговь	14
15	Сүхбаатар	15
16	Сэлэнгэ	16
17	Төв	17
18	Увс	18
19	Ховд	19
20	Хөвсгөл	20
21	Хэнтий	21
22	Улаанбаатар	22
23	Эрүүл мэндийн яам	23

8.1.5 Дөрөвдүгээр хэсэг нь олгосон гэрчилгээний дугаар байна.

8.2 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд бичилт хийх;

8.2.1 Гэрчилгээний өвөр талд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр, хаяг, хүчинтэй байх хугацаа, тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар, улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний дугаар зэргийг бичнэ.

8.2.2 Гэрчилгээг олгосон он сар, өдөр гэсэнд комиссын шийдвэрийг үндэслэн гаргасан Эрүүл мэндийн сайдын болон Эрүүл мэндийн газрын даргын тушаал, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжийн огноог бичнэ.

8.2.3 Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага гэсэн хэсэгт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн болон Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллагын нэр байна.

8.2.4 Байгууллагын нэр гэсэнд эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн нэрийг бичнэ.

8.2.5 Үйл ажиллагааны чиглэлд холбогдох хууль тогтоомжид заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны ерөнхий төрлийг зааж,

тухайн байгууллагын тусгайлан эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг хаалтанд оруулан бичиж тэмдэглэнэ.

8.2.6 Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр гэсэнд тухайн байгууллагын үйл ажиллагааны хамрах хүрээг заана.

8.2.7 Байгууллагын албан ёсны хаяг гэсэнд тухайн эрүүл мэндийн байгууллагын байршлын хаягийг бичиж тэмдэглэнэ.

8.2.8 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаарт тухайн хуулийн этгээдийг бүртгэсэн гэрчилгээний болон регистрийн дугаарыг бичнэ.

8.2.9 Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байх тохиолдолд зохих байгууллагаас олгосон гэрчилгээний дугаарыг бичиж тэмдэглэнэ.

8.2.10 Гарын үсэг хэсэгт комиссын дарга гарын үсэг зурна.

8.2.11 Гэрчилгээний ар талд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлт болон тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан талаарх бүртгэл, мэдээллийг комиссын шийдвэрийг тус тус үндэслэн бичиж тэмдэглэнэ.

8.2.12 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны улсын стандартад үндэслэн гаргасан шалгуур үзүүлэлтээр шинжээчдийн хийсэн үнэлгээний дүнг хавсаргана.

8.3 Гэрчилгээг хэвлэх;

8.3.1 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний маягыг 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу хэвлэлийн байгууллагатай гэрээ байгуулан хэвлүүлнэ.

8.3.2 Гэрчилгээ нь өвөр, ар талтай байна. Гэрчилгээний өвөр талд тусгай зөвшөөрөл олгосон байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, эрхлэх үйл ажиллагааны төрөл, нутаг дэвсгэр, хаяг, хүчинтэй байх хугацаа, олгосон огноо, дугаар, улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний дугаар, комиссын даргын гарын үсэг, тамга зэргийг тус тус багтаана. Ар талд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлт болон тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан талаарх бүртгэл, мэдээлэл тусгагдана.

8.3.3 Гэрчилгээний өвөр талыг дөрвөн буландаа хээ, угалзтай ногоон өнгийн хүрээтэй, ар талыг хүрээгүй, өвөр талын зүүн дээд хэсэгт нууцлалын ил тэмдэгтэй байхаар хэвлүүлнэ.

Ес. Хариуцлага

9.1 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой энэхүү журмыг зөрчсөн аж ахуйн нэгж байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эрх бүхий байгууллагын холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

143
Эрүүл мэндийн сайдын 2013 оны
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

1. Гэрчилгээний өвөр тал

МОНГОЛ УЛС
MONGOLIA

Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
SPECIAL PERMIT TO CONDUCT PROFESSIONAL ACTIVITIES
IN MEDICAL FIELD

ГЭРЧИЛГЭЭ
CERTIFICATE

Олгосон _____ он _____ сар _____ өдөр _____ Дугаар _____
(year) (month) (date) (number)

Байгууллагын нэр _____
(Name of organization)

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр _____
(name of license holder)

Үйл ажиллагааны чиглэл _____
(Type (field) of activity)

Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр _____
(Permitted territory)

Байгууллагын албан ёсны хаяг _____
(address of organization)

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар _____
(State registration number)

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар _____
(number of certificate of foreign incorporated company)

Гэрчилгээ _____ он _____ сар _____ өдөр хүртэл хүчинтэй.
(certificate) (year) (month) (date) (valid)

КОМИССЫН ДАРГА _____ Гарын үсэг /НЭР /
(Chairman of the Commission,) (Signature) (chairman's name)

2. Гэрчилгээний ар тал

Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл (Amendments to special permit's document)

Д/д	Нэмэлт өөрчлөлтийг зөвшөөрсөн шийдвэрийн дугаар, огноо (Number and date of decision on amendment)	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга (Content of amendment)	Бүртгэсэн	
			Огноо (date)	Ажилтан (officer)

_____ он _____ сар _____ өдөр хүртэл сунгав.
(year) (month) (date) (extended)

Комиссын дарга _____ Гарын үсэг
(Chairman of the Commission/) (Signature)

_____ он _____ сар _____ өдөр хүртэл сунгав.
(year) (month) (date) (extended)

Комиссын дарга _____ Гарын үсэг
(Chairman of the Commission) (Signature)

_____ он _____ сар _____ өдөр хүртэл сунгав.
(year) (month) (date) (extended)

Комиссын дарга _____ Гарын үсэг
(Chairman of the Commission) (Signature)

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.